



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 400

Улаанбаатар хот

「Д.Тогтохсүрэнг ажилд түр томилох тухай」

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.2, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2024 оны 05/13428 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Дуламдоржийн Тогтохсүрэнг 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн саналыг авч, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, зөвшөөрөл авсаны үндсэн дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Тогтохсүрэнтэй “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогтод даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ